

Ашиг сонирхол ба эрх зүй

Interest and Law

Батаагийн Тэмүүлэн

Хууль зүйн ухааны доктор (Dr.Jur.).

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн

Хувийн эрх зүйн тэнхимийн дэд профессор

Улаанбаатар хот, Монгол Улс

temuulen@num.edu.mn



[Товч утга]

ХБНГУ-ын судлаач Йеринг анх ойлголтын хууль зүйг шүүмжлэн, орчин үеийн ашиг сонирхлын хууль зүйн суурийг тавьсан ач гавьяатай билээ. Түүний хөгжүүлсэн нөмлөл дээр суурилан Хек судлаач ашиг сонирхлын хууль зүйг хөгжүүлсэн бөгөөд орчин үед эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудад ашиг сонирхлын хууль зүй өргөн хэрэглэгдэж буй юм.

Монгол Улсын Иргэний хуульд болон бусад холбогдох хуулиудад ашиг сонирхлын хууль зүйн аргачлалын тусгасан эсэх, хэрхэн тусгасныг тодорхой зохицуулалтын жишээн дээр өгүүллийн хүрээнд толилуулсан болно. Энэ нь холбогдох заалтуудыг авч хэрэглэхэд зөв аргачлал болох ашиг сонирхлын хууль зүйг хэрэглэх шаардлагатайг дахин нотлохыг оролдсон явдал юм. Үүний тулд өгүүллийн хүрээнд Йерингийн үзэл баримтлал, Хекийн концепцийг товч танилцуулсны үндсэн дээр ашиг сонирхлыг хамгаалсан жишээнүүдийг дүгнэсэн болно.

[Түлхүүр үг]

Ашиг сонирхол, Ойлголтын хууль зүй, Ашиг сонирхлын хууль зүй.

1. Йерингийн үзэл баримтлал

19 дүгээр зууны нэр хүндтэй, эрх зүйн хөгжилд томоохон хөдөлгөгч хүч болон нөлөөлсөн гэж үнэлэгддэг Германы философич, судлаачдын нэг болох Рудольф фон Йеринг¹ нь хувийн эрх зүйн институтийн анализ буюу дүн шинжилгээг нийгмийн буюу нийгмийн гишүүдийн зорилго ба ашиг сонирхолд чиглүүлэн тайлбарласан юм. Түүний ойлголтоор бол эрх зүй гэдэг нь нийгмийн хөгжлийг хөдөлгөгч арга хэрэгсэл болдгийн хувьд дан ойлголтын хууль зүйг² хэрэглэх биш, харин практик хэрэглээ, практик үр дүнд чиглэгдсэн ашиг сонирхлын хууль зүйд чиглэгдэж, амьдралд үр дүнтэй шийдэлд хүрэх ёстой.

Йерингийн үзэл баримтлалын дагуу эрх зүйн хэм хэмжээний гол чиг үүрэг нь тодорхой зорилгод хүрэхэд оршдог: нийгмийн дэг журмыг бий болгох, зөрчлийг шийдэх, ашиг сонирхлыг тэнцвэржүүлж эдийн засгийн үйл явц, процессыг баталгаажуулах... Улмаар, эрх зүйн хэм хэмжээг үндэслэж боловсруулах, бий болгох ба хэрэглэх зэрэг үйлдэл нь эдгээр хэм хэмжээний зорилго болон бодит үр дагаварт чиглэгдсэн байх ёстой. Энэ тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг түүний зорилго болон утгынх нь дагуу тайлбарлах аргачлал хэрэглэгдэж ирнэ. Үүнийг телеологийн редукцийн аргачлал хэмээн тодорхойлсон.³

Эрх буюу эрх зүйн хэм хэмжээ болгон ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгддэг. Хэд хэдэн ашиг сонирхол хоорондоо мөргөлдөж, зөрчилдөөн үүсэх магадал бий болоход эдгээр ашиг сонирхлыг юуны өмнө үнэлж, “жигнэж”, харьцуулах шаардлагатай байдаг. Ингэсний үндсэн дээр хэрэглэх гэж буй хэм хэмжээний зорилгод хамгийн их нийцэж буй тэр л ашиг сонирхлыг хамгаалсан шийдвэр гарах ёстой бөгөөд ингэхдээ бусад хамгаалагдах ёстой ашиг сонирхлыг харгалзахгүй орхих эрсдэл багасдаг байна.⁴

Эрх зүйг буюу эрх зүйн хэм хэмжээг бодитоор хэрэгжүүлснээр тэд өөрийн ач холбогдлыг, хөгжлийг харуулж чаддаг. Йерингийн үзэж байснаар, хамгаалагдах ёстой шаардах эрх нь практик хамгаалалтгүйгээр өөрийн ач холбогдлыг алдах нь эргэлзээгүй.

Йеринг ойлголтын хууль зүй буюу эрх зүйн хэм хэмжээг хэрэглэхэд дан ганц ойлголтын хууль зүй буюу эрх зүйн абстракт

¹ Рудольф фон Йеринг (1818-1892)

² Ойлголтын хууль зүй – Begriffsjurisprudenz – эрх зүйн ойлголт, тодорхойлолтоос логик дүгнэлт хийх аргаар эрх зүйг хөгжүүлэх аргачлал. Шүүгч маргааныг шийдэхдээ 19 дүгээр зуунд хөгжиж ирсэн, төлөөлөгчид нь Фридрих Пухта, Бэрнхард Виндшайд нар.

³ Мөн тэнд.

⁴ Rapone, Vincenzo: Der Zweckbegriff im Werk Rudolf von Jherings, 2018, S. 125, 128ff.

ойлголт, тодорхойлолтуудаас логик дүгнэлт хийх арга замаар эрх зүйн зохицуулалтыг эсхүл үр дагавар үр дүнг бий болгох аргачлалыг хэрэглэх нь хангалтгүй хэмээн шүүмжилж байсан. Тухайлбал, ойлголтын хууль зүйн аргачлалаар “ өмч” гэх ойлголтын тодорхойлолтын үндсэн дээр үүнтэй холбоотой зохицуулалт, дараах ойлголтыг хөгжүүлж бий болгох нь практик амьдралд тэр болгон нийцэхгүй. Иймд, нийгмийн шаардлага хэрэгцээг, эдийн засгийн чиг үүргийг харгалзсан өөр тайлбар үндэслэл шаардлагатай хэмээн үзсэн байна.⁵

Йерингийн энэ үзэл баримтлал нь эрх зүйн хэрэглээний аргачлалыг өнөөгийн нөхцөлд хөгжихөд түлхэц болсон бөгөөд эрх зүйн хэм хэмжээний зорилго, зорилт ба зохицуулалтын харилцаа хамаарлыг хамтад нь харгалзан үзсэн тайлбар хийх аргачлалыг бий болгон, хүлээн зөвшөөрч хэрэглэхэд хүргэсэн юм. Тодруулбал, эрх зүйн хэм хэмжээний агуулга нь ойлгомжтой бус, тодорхой бус байдлаар томъёологдсон байх тохиолдолд тус хэм хэмжээний зохицуулалтын зорилгыг тодорхойлж тайлбарласнаар эрх зүйн хийдэл буюу цоорхойг бөглөх боломж нээгдэнэ. Ингэснээр, эрх зүйг хөгжүүлж буй алхам болж буй нь маргаангүй.

2. Йерингийн үзэл баримтлал болон Ашиг сонирхлын хууль зүйн аргачлал

Йеринг нь ойлголтын хууль зүйн аргачлалыг шүүмжилж, зорилгод чиглэсэн арга зүйг хөгжүүлснээр Ашиг сонирхлын хууль зүйн аргачлалыг хөгжүүлэх үндэс суурь буюу анхны суурь “ чулууг” суулгасан хэмээн үнэлэгддэг. Харин, орчин үеийн Ашиг сонирхлын хууль зүйн аргачлалыг хөгжүүлсэн судлаач, эрдэмтдийн эгнээнд юуны өмнө Филипп фон Хек⁶ багтдаг байна. Филипп фон Хек өөрийн хамтран зүтгэгч Макс Рюмелин ба Хайнрих Штолл нартай хамтран “ Ашиг сонирхлын хууль зүйн Тюбингийн сургууль” – ийг бий болгосноор өнөө үеийн Ашиг сонирхлын хууль зүйн аргачлалыг хөгжүүлсэн хэмээн зүй ёсоор үнэлэгддэг юм.⁷

- Ашиг сонирхлын хууль зүйн аргачлал

Ашиг сонирхлын хууль зүйн аргачлалын агуулгыг тайлбарлахаас өмнө “ашиг сонирхол” хэмээн ухагдахууныг тус аргачлалыг үндэслэн хөгжүүлсэн судлаачид хэрхэн тодорхойлж байсныг дурдъя.

⁵ Mecke, Cristoph-Eric: Begriff des Rechts und Methode der Rechtswissenschaft bei Rudolf von Jhering, 2019, S. 87.

⁶ Philipp Heck (1858-1943)

⁷ Tschentscher, Axel: Philipp Heck, Gesetzesauslegung und Interessenjurisprudenz, in: Archiv fuer civilistische Praxis, Bd. 112, 1914, S. 6, 8 f.

Ашиг сонирхол хэмээх ойлголтыг агуулгын хувьд өргөтгөсөн байдлаар тодорхойлж ирсэн, тодруулбал, ашиг сонирхол нь хүн буюу субъект болон эд зүйлс, материаллаг бус үнэт зүйлсэд хамаарах ойлголт.⁸

Хекийн үзэл баримтлалын дагуу, хүн болгоны, этгээд болгоны ашиг сонирхол нь өөр хоорондоо зөрчилдөх боломжтой буюу эрсдэлтэй. Эдгээр ашиг сонирхлыг эрх хэрэгжүүлэгч буюу хэрэглэж буй байгууллагын зүгээс, этгээдээс үнэлж, дүгнэж, - жигнэх” ёстой байдаг юм. Ийнхүү үнэлж дүгнэх үйлдэл нь юуны өмнө үнэт зүйлсийг үнэлж дүгнэх ажиллагаанаас эхэлдэг. Харин үнэт зүйлсийг үнэлж дүгнэх процессын суурьт нийгмийн, нийгэмлэгийн нийтлэг зарчим байх бөгөөд эдгээр нь ашиг сонирхлыг үнэлэх, дүгнэх масштаб буюу хэмжүүр болж ирдэг байна.⁹

Йерингийн үзэл баримтлал дээр суурилан, эрх зүйн хэм хэмжээ гэдэг бол хууль тогтоогчоос ямар болон хэний ашиг сонирхлыг хамгаалах талаар тогтоосон буюу гаргасан шийдэл байдаг байна, ингэснээр ашиг сонирхлын зөрчлийг арилгах зорилгыг хэрэгжүүлнэ. Улмаар, хууль хэрэглэж, маргааныг шийдэх гэж буй шүүгч юуны учир, яагаад хууль тогтоогчийн зүгээс тодорхой ашиг сонирхлыг хамгаалах тухай шийдэл гаргасныг ойлгон тодруулж, шийдэх гэж буй маргаанд ямар ашиг сонирхол хоорондоо зөрчилдөж буйг тогтоож, тухайн хэм хэмжээгээр амар ашиг сонирхлыг хамгаалах зорилго агуулсныг ойлгосны үндсэн дээр шийдвэр гаргах ёстой.

3. Ашиг сонирхлын тухай өнөө үеийн ойлголт

Ашиг сонирхол гэх ойлголтыг дараах байдлаар тодорхойлсон байна:

“Ашиг сонирхол гэдэг нь тодорхой хүн, үйл явдал эсхүл эд зүйлсэд чиглэгдсэн когнитив шинжтэй анхаарал, сониуч зан, сэтгэл, сэтгэл зүйн хөдлөл юм”.¹⁰ Харин когнитив гэх ойлголтыг хүний тархи, оюун ухааны сэтгэлгээ, танин мэдэх үйл ажиллагаа гэж тайлбарладаг байна.¹¹

Улмаар, ашиг сонирхол гэдэг нь хүн эд зүйлс, эд хөрөнгө, үйл явдалд сэтгэлгээ, оюун ухаанаараа сонирхож буй анхаарал, сониуч зан, сэтгэл зүйн хөдлөл байх нь.

Харин, эрх зүйн салбарт ашиг сонирхол гэх ухагдахууныг эрх

⁸ Kallfass, Wilfrid: Die Tuebinger Schule der Interessenjurisprudenz, 1972, S. 10.

⁹ Мөн тэнд.

¹⁰ Schuldrecht, Besondere Teil, in: Gabler Wirtschaftslexikon, <https://wirtschaftslexikon.gabler.de/>.

¹¹ in: gesundheit.gv.at, <http://www.gesundheit.gv.at>.

зүйд тодорхой чиг үүрэг гүйцэтгэж буй хувийн хэрэгцээ шаардлага, хүсэл болон зорилгыг ойлгодог байна.¹²

Эрх зүйн салбарын үүднээс ашиг сонирхлыг үндсэн дараах төрөлд ангилж болдог, үүнд:

- Абсолют буюу туйлын ашиг сонирхол. Энэ төрөлд хамааралтай ашиг сонирхлыг бусад этгээдийн ашиг сонирхлоос үл хамааран эрх зүйгээр хамгаалагдах ёстой, шаардлагатай ашиг сонирхлыг хэлдэг. Тухайлбал, амьд явах, бие махбодын хувьд халдашгүй байх ашиг сонирхол

- Харьцангуй ашиг сонирхол. Энэ төрөлд бусад этгээдийн ашиг сонирхолтой тодорхой этгээдийн ашиг сонирхол хэрхэн, яаж харьцуулагдан, жигнэгдэж, үнэлэгдэхээс хамааран эрх зүйн хамгаалалт олгож буй ашиг сонирхлыг хамааруулдаг. Жишээлбэл, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн зохицуулагдсан Нэрийн хувьд эдлэх эрхийг дурдаж болно.

- Хувийн ашиг сонирхол. Энэ төрөлд хувь этгээдийн хүсэл, шаардлага хэрэгцээг хамааруулдаг байна, жишээ нь, өөрийн өмчийг хамгаалуулах ашиг сонирхол, гэрээний үүргийн зөрчилтэй хамааралтай шаардах эрхээ хэрэгжүүлэх ашиг сонирхол гм.

- Нийтийн ашиг сонирхол – энэ төрөлд хамаарах ашиг сонирхол нь нийтийн эрх зүйн салбараар хамгаалагдаж буй ашиг сонирхлыг ойлгодог байна.¹³

4. Хувийн эрх зүйгээр хамгаалагдаж буй ашиг сонирхол

4.1. Иргэний хуульд тусгагдсан, хамгаалагдаж буй ашиг сонирхлыг жишиг

Өгүүллийн эхний хэсгүүдэд толилуулсан ашиг сонирхол гэх ойлголт нь абстракт ойлголт биш, харин хувийн эрх зүйн эх сурвалж болсон хуулиудад, тухайлбал, Иргэний хууль ба холбогдох бусад хуулиудад тусгагдаж, хамгаалагдсан байдаг байна.

Үүний нэг жишээ нь Иргэний хуулийн 20 болон 21 дүгээр зүйлд хуульчлагдсан Нэрийн хувьд эдлэх эрх юм.

Хувь хүн өөрийн нэрийг ашиглаж байж хэмээн нэрийн ач холбогдол нь илрэх нь гарцаагүй. Улмаар, тодорхой хүний нэр нь тэр хүн хэн болохыг тодорхойлж, бусдаас ялгах чиг үүргийг гүйцэтгэдэг тул, хүн өөрийн нэрээ зориулалтын дагуу ашиглаж, өөрийгөө хэн болохыг таниулан тодорхойлж, бусдаас ялгах ашиг сонирхолтой байх нь ойлгомжтой. Улмаар, нэртэй холбоотой хүний дараах ашиг

¹² Creifelds, Rechtswoerterbuch, 18. Aufl., 2004, S. 699.

¹³ Мөн тэнд.

сонирхол урган гарч ирнэ, энэ нь хувь хүн өөрийнх нь нэрийг зөвхөн өөрийг нь тодорхойлох бусдаас ялгах зорилгоор хэрэглэхээс биш, өөр нэртэй өөр хүнийг өөрийнх нь нэрийг ашиглан хууль бус үйлдэл хийлгэхээргүй байх ашиг сонирхолтой байх нь ойлгомжтой.¹⁴

Түүнчлэн, хүн өөрийн нэрийг өөрийн үйлдэл, үйл ажиллагааг, эд зүйлстэй холбохдоо зөвхөн өөрийгөө ийм байдлаар хэн болохыг таниулж ялгарах ашиг сонирхолтой байх нь маргаангүй. Улмаар, хэрэв өөр нэгэн этгээд тус хүний нэрийг бараа үйлчилгээ, аж ахуйн нэгжтэй холбон ашиглавал нэрийн эзний хэн болохыг төөрөгдүүлж буй биш, харин гагцхүү нэрийн эзний зөвшөөрөлгүй нэрийг нь ашиглаж буй үйлдэл болох нь. Энэ тохиолдолд нэрийн эзэн нь өөрийнх нь зөвшөөрөлгүй нэрийг нь ашиглахыг хориглох ашиг сонирхолтой байх нь маргаангүй. Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Иргэний нэрийг хууль бусаар ашиглахыг” хориглосон. Үүнтэй холбоотой “иргэний нэрийг хууль бусаар ашиглах” гэх үйлдэлд ямар үйлдэл эсхүл эс үйлдэл багтах асуудал тавигдана. хүний нэр нь тус хүнийг хэн болохыг тодорхойлох, бусдаас ялгах чиг үүрэг гүйцэтгэж, үүн дээр суурилан хувь хүн өөрийн нэрээ өөрөө ашиглан бусдад өөрийгөө таниулах, хэн болохыг харуулах, бусдаас өөрийгөө ялгах ашиг сонирхолтой байдаг тул энэхүү ашиг сонирхлыг зөрчиж, хүний нэрийг ашигласан үйлдэл нь хууль бус үйлдэл байх нь маргаангүй.¹⁵

Хүний нэрийг эд зүйлс, үйлдэл, үйлчилгээтэй холбож болдог бөгөөд үүнд суурилсан ашиг сонирхлыг анхаарвал, хүн өөрийнх нь нэрийг өөрт нь хамааралгүй үйлдэл, үйлчилгээ, эд зүйлстэй холбохгүй байх ашиг сонирхолтой бөгөөд тус ашиг сонирхлыг зөрчсөн үйлдэл нь хууль бус бөгөөд нэрийг хууль бусаар ашиглаж буй үйлдэл болно. Түүнчлэн, хувь хүний нэрийг тодорхой үйлчилгээ үйл ажиллагаа, үйлдэл, эд зүйлстэй холбох үед нэрийн эзэн өөрөө зөвшөөрөл олгох ашиг сонирхолтой байх тухай дурдсан тул энэ ашиг сонирхлыг зөрчсөн үйлдэл нь нэрийг хууль бусаар ашиглах үйлдэлд багтах нь үндэслэлтэй байна.¹⁶

Үүнээс гадна, нэр хүнд бүхий, эдийн засгийн агуулгатай, сайн чанарын үйлчилгээ, үйл ажиллагааны бэлэг тэмдэг болсон өөрийн нэрийг бусад этгээд эдийн засгийн давуу тал, ашиг орлого олох зорилгоор ашиглахыг зөвшөөрөхгүй байх ашиг сонирхолтой байх бөгөөд үүнийг зөрчиж буй үйлдэл нь мөн бусдын нэрийг хууль бусаар ашиглах үйлдэлд багтана.

Улмаар, Иргэний хуулийн 20, 21 дүгээр зүйлүүдэд хувь хүний

¹⁴ Klippel, D.: Der zivilrechtliche Schutz des Namens, 1995, S. 357.

¹⁵ Мөн тэнд.

¹⁶ Мөн тэнд.

Нэрийн хувьд эдлэх эрхээр хүний хувийн ашиг сонирхлыг хамгаалсан байна. Үүнд, нэрийн хувьд эдлэх эрхээр хамгаалагдаж буй ашиг сонирхол нь туйлын шинжтэй байна.

4.2. Дүрсийн хувьд эдлэх эрх

Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5., 21.6-т Дүрсийн хувьд эдлэх эрхийг субьектив эрх болохын хувьд хуульчилсан.

Хүн өөрийн гадаад дүрсийн хувьд өөрийгөө хэн болохыг бусдад таниулах, харуулах, бусад хүмүүсээс өөрийгөө ялгах, өөрийгөө хувь хүний хувьд хэн болохыг илэрхийлэх, эд зүйлс, үйлчилгээтэй өөрийгөө холбох зэрэг эдийн бус болон эдийн засгийн шинжтэй ашиг сонирхолтой байдаг.¹⁷

Эдгээр ашиг сонирхлыг Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5., 21.6-аар хамгаалсан. Харин, ийнхүү Иргэний хуулиар хамгаалагдсан хувь хүний ашиг сонирхол нь харьцангуй ашиг сонирхлыг тус хуулийн холбогдох заалтаар хуульчилж хамгаалсан. Үүний үндэслэл нь Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-т заасны дагуу хувь хүний дүрсийг сургалт эрдэм шинжилгээний ажил, ажил хэргийн хүрээнд олон нийтийг хамарсан үйл ажиллагааны явцад уг этгээдийг дүрсэлсэн зургийг түүний зөвшөөрөлгүйгээр нийтэлж болохоор хуульчилсан тул энэ тохиолдолд хувь хүний дүрстэй холбоотой ашиг сонирхол нь туйлын утгаар хамгаалагдахгүй, харин олон нийтийн ашиг сонирхол хамгаалагдаж байна. Улмаар, хувь хүний дүрсийн хувьд эдлэх ашиг сонирхлыг хамгаалах уу эсхүл олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах уу гэх шийдвэрийг хууль хэрэглэн шийдвэр гаргаж буй шүүх хоёр талын ашиг сонирхлыг хуульд нийцүүлэн үнэлж, харьцуулсны үндсэн дээр шийдвэрлэх нь. Үүнээс, Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.8, 21.6 дугаар заалтаар харьцангуй шинжтэй ашиг сонирхлыг хамгаалан хуульчилсан байна.

4.3. Хүний нэр төр, нэр хүнд, ажил хэргийн нэр хүндийн хувьд эдлэх эрхээр хамгаалагдаж буй ашиг сонирхол

Субьектив эрхийн энэ тодорхойлолтыг Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 -т зохицуулсан хүн нэр төртэй, алдар хүндтэй, ажил хэргийн нэр хүндтэй байх эрхийн хувьд авч хэрэглэвэл, хувь хүн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гэх үнэт зүйлстэй ашиг сонирхлоороо холбогдож байна. Тодруулбал, хүн өөрийн нэр төртэй байх, алдар хүндтэй байх, ажил хэргийн нэр хүндтэй байх ашиг сонирхолтой байх бөгөөд ашиг сонирхлоо хамгаалах, хамгаалуулах боломжийг түс субьектив эрхийг Иргэний хуулиар хүлээн зөвшөөрснөөр олгож байна. Эцсийн үр дүнд хүний эдгээр ашиг сонирхлыг Иргэний хуулиар хамгаалж буй нь ашиг сонирхлоор

¹⁷ Temuulen, B.: Das Recht am eigenen Bild als Persönlichkeitsrecht, 2006, S. 125-135ff.

нь дамжуулан хүнийг өөрийг нь үнэ цэнтэй, дахин давтагдашгүй, өөрийн дотоод ертөнц, зан суртахуун, ёс зүйн үнэт зүйлстэй, өөрөө өөрийгөө хэн гэдгийг тодорхойлох эрхтэй, нийгэмд өөрийн байр суурь, хүндлэлтэй байх цорын ганц эрхэмсэг оршихуй мөн болохыг нь хүлээн зөвшөөрч хамгаалж буйн илрэл юм.

Хүний талаар олон нийтэд мэдээлэл тараах үйлдэл нь наг талаас тус хувь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбоотой ашиг сонирхолтой шууд хамааралтай болохоос гадна, нөгөө талаас олон нийтийн ба хэвлэл мэдээллийн хэрэгслийн ашиг сонирхолтой уялдаатай байдаг.

Үүнийг тодруулбал, хувь хүний талаар мэдээлэл олон нийтэд тараах нь нэгдүгээрт, олон нийтийн зүгээс тухайн хүний талаар мэдээлэл авах ашиг сонирхолтой байна. Үүнд, тухайн хүн нийгэмд танигдсан, улс төр, спорт, бизнес, соёлын салбарт хэр зэрэг танигдсан байгаагаас хамааран олон нийтийн ашиг сонирхол төдий зэрэг өндөр байх нь тодорхой. Түүнчлэн, олон нийтээс гадна хэвлэл мэдээллийн хэрэгслийн мэдээлэл тараах ашиг сонирхол байна. Ингэхдээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олон нийтийн мэдээлэл авах ашиг сонирхлыг хангаж буй нэрийн дор өөрийн худалдаалах хэвлэлийн тоог ихэсгэх, цахим хуудасны хандалтыг нэмэгдүүлэх, үр дүнд нь өөрийн эдийн засгийн ашиг сонирхлыг хангахыг хичээж буй нь маргаангүй.

Үүнээс дүгнэвэл, нэг талаас, хувь хүний хүндлүүлэх, нийгэмд нэр хүндтэй байх, нөгөө талаас олон нийтийн мэдээлэл авах, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эдийн засгийн ашиг сонирхол нь хоорондоо өрсөлдөж байдаг.

Энэ тохиолдолд Иргэний хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т хууль тогтоогч хүний талаар тарааж буй мэдээлэл нь үнэн бодит байдалд нийцэж буй эсэхээс хамааран, өөрөөр хэлбэл тус шалгуураас хамааран, хүний эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслийн, олон нийтийн ашиг сонирхлыг алиныг нь хамгаалах тухай шийдвэр гаргах эрхийг шүүхэд олгосон байна. Тодруулбал, хүний талаар тараасан мэдээлэл нь үнэн, бодит байдалд нийцсэн мэдээлэл байвал олон нийтийн мэдээлэл авах ашиг сонирхлыг болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн ашиг сонирхлыг хамгаалсан шийдвэр гаргах нь. Харин хүний талаар тараасан мэдээлэл нь худал болох нь тогтоогдвол, тухайн хүний ашиг сонирхлыг хамгаалах шийдвэр гаргах нь.

4.4. Хууль ёсны ашиг сонирхол

Хувийн эрх зүйн зарим нэг эх сурвалжуудад “ хууль ёсны ашиг сонирхол” -ын тухай ухагдахууныг зохицуулалтад тусгасан байдаг. Тухайлбал, Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-т “ Хуульд өөрөөр заагаагүй бол байгууллагын албан үйл

ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал, хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно”. – гэж хуульчилсан байна. Энэ заалтыг харилцааг зохицуулах зорилгоор авч хэрэглэхэд “ хууль ёсны ашиг сонирхол “ гэх ухагдахууныг тайлбарлах шаардлагатай болж ирнэ. Учир нь, хуулийн тус заалтаар байгууллагын “ хууль ёсны ашиг сонирхол”-ыг хамгаалж байна гэж энэ хэм хэмжээний зорилгыг тайлбарлах боломжтой. Улмаар, Йерингийн үзэл баримтлалыг жишиг болгон орчин үед хэрэглэгдэг хэм хэмжээний агуулгыг түүний зорилгын дагуу буюу телеологийн редукийн аргачлалыг¹⁸ хэрэглэн тайлбарлавал, байгууллагын зах зээл дэх байр суурийг хамгаалах, хадгалахад чиглэгдсэн, ашиг орлого нэмэгдүүлэх, зарлага багасгах чиг үүрэг гүйцэтгэдэг, эдийн засгийн үнэ цэнтэй, цөөн тооны хүмүүс мэдэхэд зориулагдсан техникийн, бизнесийн, зохион байгуулалт, технологийн эдийн болон эдийн бус мэдээллийг байгууллагын нууцад хамаарах мэдээллийг бусад этгээдэд задруулахгүй байх боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн. Өөрөөр хэлбэл, бизнесийн байгууллагын зах зээл дэх эзэлж буй байр суурь, олсон ололт, давуу талыг хамгаалахад тус заалтын зорилго оршиж байна. Улмаар, “ хууль ёсны ашиг сонирхол “ гэдэг нь бизнесийн байгууллагын ийнхүү зах зээлд олж авсан байдал, ашиг орлого, туршлага мэдлэгийг хамгаалахад чиглэгдсэн ашиг сонирхол байх нь.

Түүнчлэн, “ хууль ёсны” гэх шинж нь тухайн ашиг сонирхол нь Байгууллагын нууцын тухай хуулийн зорилго, зорилт, зарчимд нийцсэн, гэхдээ байгууллагын талаар мэдээлэл олж авах ашиг сонирхолтой талын эрх, ашиг сонирхлыг зөрчөөгүй байхыг ойлгохоор байна. Эцэст нь, байгууллагын “ хууль ёсны ашиг сонирхол “ гэх ойлголтыг авч хэрэглэхдээ бизнесийн байгууллагын зах зээлд олж авсан байр суурь, тус байгууллагын орлого ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн маркетинг, менежментийн ололт, амжилт, мэдээлэл, техникийн шийдэл гэх мэт зүйлсийг хамгаалахад чиглэгдэж буй, эсрэг талын ашиг сонирхлыг зөрчөөгүй, хамгаалагдах ёстой ашиг сонирхлыг ойлгохоор байна. Харин, тус заалтыг авч хэрэглэхдээ, байгууллагын хамгаалагдах ёстой ашиг сонирхол мөн эсэхийг тогтоохын тулд тус ашиг сонирхлыг эсрэг ашиг сонирхолтой харьцуулан, үнэлж дүгнэсний үндсэн дээр хамгаалагдах ёстой эсэх талаар шийдвэр гаргах ёстой болох нь. Энэ тохиолдолд ашиг сонирхлын хууль зүйг хэрэглэх нь маргаангүй. Улмаар, тус хуулийн заалтаар “ харьцангуй”

¹⁸ Larenz/Canaris, Juristische Methodenlehre, 3. Aufl., 1995, S. 78.

шинжтэй ашиг сонирхол хамгаалагдаж байна.

4.5. Эерэг ба сөрөг ашиг сонирхол

Иргэний хуулийн гэрээний үүргийн зөрчил болон хүчин төгөлдөр бус гэрээ хэлцэл байгуулсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх асуудал үүсдэг. Энэ тохиолдолд ямар хохирлыг нөхөн төлүүлэх нь үндэслэлтэй болох талаар шийдвэр гаргахад хохирол нөхөн төлүүлэх зохицуулалтын үндэс болж буй ашиг сонирхлыг сайтар ойлгож байх шаардлагатай байдаг.

Энэ тохиолдлуудад эерэг ба сөрөг ашиг сонирхлын асуудал хөндөгддөг байна. Эерэг ашиг сонирхол хөндөгдөж буй нөхцөл байдалд гэрээ, хэлцлийн дагуу хүлээсэн үүргээ үүрэг гүйцэтгэгч тал гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх асуудал яригддаг байна.¹⁹ Үүнд, үүрэг гүйцэтгэгч тал үүргээ гүйцэтгэсэн эсхүл зохих ёсоор гүйцэтгэсэн бол ямар эрх зүйн байдалд үүрэг гүйцэтгүүлэгч байх байсан, тэр нөхцөл байдлыг бий болгох зорилгоор хохирлын хэмжээ болон төрлийг тогтоодог.

Харин сөрөг ашиг сонирхол хөндөгдөж буй тохиолдлыг Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.6-т зохицуулсан. Үүнд, гэрээ хэлцэл хүчин төгөлдөр бус байх нөхцөлд гэм буруугүй тал нь ийнхүү хүчин төгөлдөр хэлцлийг огт байгуулаагүй буюу энэ талаар огт мэдлэггүй, хийхийг оролдоогүй тохиолдолд ямар эрх зүйн байдалд байх байсан, тэр байдлыг нөхөн сэргээхэд хохирлын нөхөн төлөлт чиглэгддэг байна. Тодруулбал, энд итгэл үнэмшилд учруулсан хохирлыг нөхөн төлөх асуудал яригддаг.

Дээрх тохиолдлуудад харьцангуй биш, харин хувийн ашиг сонирхлыг хамгаалан зохицуулсан байна.

Дүгнэлт

Йерингийн боловсруулсан концепцийн дагуу ойлголтын хууль зүйг ашиглах нь дэндүү өрөөсгөл тул түүний үзэл баримтлалыг цаашид хөгжүүлсэн Хекийн ашиг сонирхлын хууль зүй нь Монгол Улсын холбогдох хуулиудад мөн тусгагдсан байна. Үүнд, нэн ялангуяа хувийн эрх зүйн эх сурвалж болох Иргэний хуулийн материаллаг бус үнэт зүйлсийг хамгаалж буй оршихуйн субъектив эрхүүдэд илрэлээ олсон. Оршихуйн эрхийн хувьд хамгаалалтын гол зүйл нь хөндөгдөж буй ашиг сонирхол мөн бөгөөд үүнийг ойлгосны үндсэн дээр эдгээр зохицуулалтыг хэрэглэхэд хялбар болох нь маргаангүй. Үүнд

¹⁹ Larenz, Lehrbuch des Schuldrechts Allgemeiner Teil, 1999, S. 439.; Brox/Walker, Allgemeiner Teil des BGB, 33. Aufl., 2009, S. 149.; Schulze, Buergerliches Gesetzbuch, Handkommentar, 2007, § 134.

ихэвчлэн харьцангуй шинжтэй ашиг сонирхол хамгаалагдаж буй тул тус хэм хэмжээг хэрэглэхэд ашиг сонирхлын хууль зүйн аргыг хэрэглэх нь оновчтой юм.

Түүнчлэн бусад хуулиудад хуульчлагдсан “ хууль ёсны ашиг сонирхол” гэх ойлголтыг тайлбарлахдаа Йерингийн суурийг нь тавьсан телеологийн редукци буюу зорилгын дагуу тайлбарлах аргачлалыг хэрэглэх нь оновчтой.

Иргэний хуульд харьцангуй шинжтэй ашиг сонирхлыг хамгаалахаас гадна хувийн төрөлд хамаарах ашиг сонирхол болох эерэг ба сөрөг ашиг сонирхлыг холбогдох заалтуудаар зохицуулсан байна.

[Ном зүй]

- Brox/Walker, *Allgemeiner Teil des BGB*, 2009.
- B. Temuulen, *Das Recht am eigenen Bild*, 2006.
- Creifelds, *Rechtswörterbuch*, 2004.
- “Gabler Wirtschaftslexikon”, <https://wirtschaftslexikon.gabler.de>,
- “Gesundheitsportal Österreich”, <https://www.gesundheit.gv.at>, 2026
- Kallfass, Wilfrid, *Die Tuebinger Schule der Interessenjurisprudenz*, 1972.
- Klippel. D., *Der zivilrechtliche Schutz des Namens*, 1995.
- Larenz/Canaris, *Juristische Methodenlehre*, 3. Auflage, 1995.
- Larenz, *Lehrbuch des Schuldrechts Allgemeiner Teil*, 1999.
- Mecke, Christoph-Eric, *Begriff des Rechts und Methode der Rechtswissenschaft bei Rudolf von Jhering*, 2019.
- Rapone, Vincenzo, *Der Zweckbegriff im Werk Rudolf von Jherings*, 2018.
- Sartori, Guido, *Rudolf von Jhering: Vater der teleologischen Jurisprudenz*, 2013.
- Schulze, *Bürgerliches Gesetzbuch, Handkommentar*, 2007.
- Tschentscher, Axel, Philipp Heck, “Gesetzesauslegung und Interessenjurisprudenz, 1914”, *Archiv fuer civilistische Praxis*, 112, 1914.

[Abstract]

Interest and Law

Temuulen Bataa

Doctor of Laws (Dr.Jur.).

Associate Professor at the Private Law Department,

School of Law, National University of Mongolia

Ulaanbaatar, Mongolia

German researcher Jering is credited with first criticizing the method of jurisprudence of concepts and laying the foundation for modern jurisprudence of interests. Based on the theory he developed, researcher Heck developed the jurisprudence of interests, and jurisprudence of interests is widely used in countries with a continental legal system today.

The article presents the case of whether and how the jurisprudence of interests is reflected in the Civil Code of Mongolia and other relevant laws using specific regulatory examples. This is an attempt to prove once again that the right method for applying the relevant provisions is the need to use the law of interest. To this end, the article briefly introduces Jering's concept and Heck's concept and researcher summarizes examples of protecting interests.

[Keywords]

Interest, Jurisprudence of Concepts, Jurisprudence of Interests.